



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8107

Улаанбаатар хот

2025 оныг “Түншлэл-Үйлчилгээний соёлыг
дээшлүүлэх жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, 2024 оны зорилтот жилийн ололт, амжилтыг бататгах, бүх шатанд үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд 2025 оныг “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

2. Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд аж аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэдийн саналыг тусган боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

4. Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээг байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган салбар дундын уялдаа холбоог хангах, түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулан үр дүн гаргаж ажиллахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5. Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, явц үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн
А.С.В. дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:
Гишүүд:

Засаг даргын орлогч
Дүүргийн менежер
Засаг даргын Тамгын газрын дарга
Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зохион
байгуулалтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Цэргийн штабын дарга
Нэгдүгээр хорооны Засаг дарга
Хоёрдугаар хорооны Засаг дарга
Дотоод аудитын албаны дарга
Худалдан авах ажиллагааны албаны дарга
Газар зохион байгуулалтын албаны дарга
Боловсролын хэлтсийн дарга
Нийгмийн даатгалын газрын дарга
Татварын хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга
Онцгой байдлын хэлтсийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Багахангайн Теле камерын хяналтын дэд төв ОНӨТҮГ-ын
дарга
Багахангай Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих
төвийн захирал
Биеийн тамир, спортын хорооны дарга
Соёлын ордны захирал
Эрүүл мэндийн төвийн дарга
Ерөнхий боловсролын 91 дүгээр сургуулийн захирал
Ерөнхий боловсролын 94 дүгээр сургуулийн захирал
"Насан туршийн суралцахуйн төв"-ийн захирал
44 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
"Илч-Орд" ОНӨААТҮГ-ын захирал
Багахангай Ус суваг ашиглалтын товчооны дарга
Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк ХК-ны
захирал
Багахангайн Тохижилт ОНӨААТҮГ-ын захирал
Багахангай Гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын захирал
Мал эмнэлгийн тасгийн дарга
Багахангай өртөөний дарга
Улаанбаатар Төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн
нэгдүгээр ангийн Багахангай цахилгаан шугам сүлжээний
хэсгийн мастер
Улаанбаатар Төмөр замын Барилга засвар ашиглалт
үйлчилгээний ангийн Багахангай хэсгийн дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Нарийн бичиг: